



## МОНГОЛ АЛТ ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 04 сарын 21-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн тайлан,  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг  
хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9, “Монгол Алт” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.3 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Алт” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Тус компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Цолмонд тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.АМАРСАНАА





## МОНГОЛ АЛТ ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 04 сарын 21-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот


Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
зарим гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.4, “Монгол Алт” Хувьцаат компанийн дүрмийн 8.4 дэх хэсгийн 8.4.7 дахь заалт болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын ... тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Монгол Алт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Саруул, Б.Батжаргал нар чөлөөлөгдөх хүсэлт гаргасантай холбогдуулан бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Төлөөн удирдах зөвлөлийн дээрх гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Лувсандагвын Амарсанаа, Батмөнхийн Цэлмэг нарыг сонгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлыг 2023 оны 5 дугаар сард багтаан хуралдуулж ТУЗ-ийн даргыг сонгох, ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилуулах, дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаарх мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.АМАРСАНАА





## МОНГОЛ АЛТ ХК

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

20 23 оны 04 сарын 11 -ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны зардлын төсөв, дарга,  
гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, “Монгол Алт” Хувьцаат компанийн дүрмийн 7.8 дугаар зүйлийн 7.8.7 болон тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын .... тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:


1. “Монгол Алт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2023 оны зардлын төсвийг өмнөх оны жишгээр тогтоосугай.
2. “Монгол Алт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал М.Цолмонд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.АМАРСАНАА



Монгол-Алт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн  
05. тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭ**

№	ТУЗ-ийн гишүүний нэр	1 сарын цалин /төг/¹	1 жилийн цалин
1	Ердийн гишүүн	45000	540000
2	Ердийн гишүүн	45000	540000
3	Ердийн гишүүн	45000	540000
4	Ердийн гишүүн	45000	540000
5	Ердийн гишүүн	45000	540000
6	Ердийн гишүүн	45000	540000
7	Хараат бус гишүүн	45000	540000
8	Хараат бус гишүүн	45000	540000
9	Хараат бус гишүүн	45000	540000
10	Нарийн бичгийн дарга	25000	300000
	Нийт	430000	5160000